

## НОГООН БАЙГУУЛАМЖИЙН 20.. ОНЫ БҮРТГЭЛ

### 1. ХАЯГИЙН ХЭСЭГ

КОД

Дүүргийн нэр:


Хорооны дугаар:

1. Хорооны Засаг дарга жил бүрийн 12-р сарын 5-ны дотор ногоон байгууламжийн бүртгэлийг дүүргийн ЗДТГ-т цахим хэлбэрээр хүргүүлнэ.
2. Дүүргийн ЗДТГ нь бүртгэлийг хороо бүрээр хянаж баталгаажуулан дүүргийн хэмжээнд нэгтгэж, цахим хэлбэрээр 12-р сарын 15-ны дотор УБ хотын ЗАА-нд хүргүүлнэ.
3. УБ хотын ЗАА нь ҮСХ-нд жил бүрийн 12-р сарын 30-ны дотор цахим хэлбэрээр хүргүүлнэ.

### 2. МЭДЭЭНИЙ ХЭСЭГ

№	Ногоон байгууламжийн нэр, байршил	Байнгын арчил- гаатай эсэх  (тийм-1, үгүй -2)	Батлагдсан зураг төслөөр	Ногоон байгууламжийн хэмжээ (м <sup>2</sup> )								
				Нийт хэмжээ (зүлэгтэй болон зориулалтын тохижилттой)	үүнээс байршлаар							Гол, горхи, далан суваг, бусад газарт
					Нийтийн эзэмшлийн газар	Авто болон явган хүний зам дагуу	Аж ахуйн нэгж, байгуул- лагын орчим	Орон сууцны орчим	Гэр хороол- лын өрхийн хашаанд	Тусгай зориулал тын	9	
А	1	2	3	4	5	6	7	8	9	10		
	Дүн											

Шаардлагатай тохиолдолд ЭАБ-1 маягтын дагуу нэмэлт хуудсаар мэдээллийг цуглуулна.

Бүртгэсэн: Албан тушаал: \_\_\_\_\_ Гарын үсэг: \_\_\_\_\_ \

Хянасан: Албан тушаал: \_\_\_\_\_ Гарын үсэг: \_\_\_\_\_ \

Тамга\тэмдэг 20 ... оны ... р сарын ...

Маягт ЭАБ-1-ийн НЭМЭЛТ ХУУДАСНЫ ДУГААР: \_ \_ \_ (нэмэлт хуудасны дугаарыг заавал бичих)

## НОГООН БАЙГУУЛАМЖИЙН 20.. ОНЫ БҮРТГЭЛ

№	А	1	2	3	4	5	6	7	8	9	10
	Дүн										

Бүртгэсэн: Албан тушаал: \_\_\_\_\_ Гарын үсэг: \_\_\_\_\_ \ \

Хянасан: Албан тушаал: \_\_\_\_\_ Гарын үсэг: \_\_\_\_\_ \ \

Тамга\тэмдэг

20 ... оны ... р сарын ...

## Ногоон байгууламжийн 20... оны бүртгэлийн маягт (ЭАБ-1) - ыг нөхөх заавар

Хорооны Засаг дарга нь нутаг дэвсгэртээ байгаа ногоон байгууламжийн бүртгэлийг жил бүрийн 10-р сарын 1-ний өдрийг тов болгон маягтын дагуу нэгтгэн гаргана.

### 1. ХАЯГИЙН ХЭСЭГ



**Байршил:** Дүүргийн нэрийг бүтнээр бичиж, Багануур дүүрэг- **01**, Багахангай дүүрэг- **04**, Баянгол дүүрэг- **07**, Баянзүрх дүүрэг- **10**, Налайх дүүрэг- **13**, Сонгинохайрхан дүүрэг- **16**, Сүхбаатар дүүрэг- **19**, Хан-Уул дүүрэг- **22**, Чингэлтэй дүүрэг- **25** гэсэн кодыг зохих нүдэнд нөхнө. Хорооны дугаарыг “Хүн ам”-ын мэдээллийн санг байгуулах заавраас харж нөхнө. Мөн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн кодыг Нийслэлийн Статистикийн газар (328787, 327946), дүүргийн Статистикийн хэлтсээс болон [www.ubstat.mn](http://www.ubstat.mn) цахим хуудсаас харах боломжтой.

### 2. МЭДЭЭНИЙ ХЭСЭГ

**Ногоон байгууламжид** батлагдсан зураг төслөөр, төлөвлөгөөний дагуу байгуулсан мод, сөөг, цэцэг, цэцгийн мандал бүхий зүлэгжүүлсэн эсвэл зүлэгний оронд зориулалтын хавтангаар тохижуулсан талбай болон мод, бүт сөөггүй дан зүлэгжүүлсэн талбайг оруулна.

**А дугаар баганад:** Тухайн ногоон байгууламжийн оноосон нэр, оноосон нэргүй бол байршиж буй хаягаар нь нэрлэж тодорхой бичнэ. Жишээ нь: Үндэсний соёл амралтын хүрээлэн, Нацагдоржийн хөшөөтэй цэцэрлэг гэх мэтээр.

**1 дүгээр баганад:** Ногоон байгууламж нь нийслэл, дүүргийн хот тохижуулах байгууллага буюу аж ахуйн нэгж, байгууллага, сууц өмчлөгчдийн холбоо, өрх зэрэг эзэмшигчийн байнгын арчилгаанд байдаг эсэхийг тогтоож, байнгын арчилгаатай бол 1, үгүй бол 2 гэсэн кодыг нөхнө.

**2 дугаар баганад:** Ногоон байгууламжийн анх батлагдсан зураг, төсөлд тусгагдсан хэмжээг м<sup>2</sup>-аар хэмжиж нөхнө.

**3 дугаар баганад:** Ногоон байгууламжийн одоо байгаа нийт хэмжээг бичнэ. Ногоон байгууламжийн хэмжээ нь байнгын арчилгаагүй болон бусад шалтгааны улмаас багасдаг. Тухайлбал, зүлэгжүүлсэн талбай нь халцгай шороо болох, мод нь ургахаа болих, зам, шугам хоолойн засвараас шалтгаалан зүлэг, цэцгийн мандал, мод сөөгийг эвдэж сүйтгэх гэх мэт. Эдгээр тохиолдолд анхны зураг, төслийн хэмжээнээс сүйтгэгдэж, багассан хэмжээг хасч одоо байгааг гарган нөхнө. Харин зүлэгний оронд хавтан, чулуу суулгаж загвар хийцийг өөрчилж тохижуулсан бол түүнийг ногоон байгууламжийн хэмжээ багассан гэж тооцохгүй. 3 дугаар баганын дүн нь 4-10 дугаар баганын дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

**Багана 4-10-д** Ногоон байгууламжийн хэмжээг маягтад өгөгдсөн ангиллын дагуу байршил, зориулалтаар нь ангилж, талбайн хэмжээг м<sup>2</sup>-аар тооцож бичнэ. 4, 5 дугаар багана нь нийтийн хэрэгцээний ногоон байгууламжид хамаарна. Нийт хэрэгцээний ногоон байгууламжийг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

**Нийтийн хэрэгцээний ногоон байгууламж** - Амралт, зугаалгын ая тухтай орчинг бүрдүүлсэн, бүх нийтээр зугаалан цэнгэх, тоглон наадах, идэвхтэй амрах, биеийн тамирын дасгал хийх нөхцлийг бүрдүүлнэ. Нийтийн хэрэгцээний ногоон байгууламжийг дотор нь цэцэрлэгт хүрээлэн, цэцэрлэг, жижиг цэцэрлэг, цэцэрлэгт гудамж, цуваа цэцэрлэг гэж ангилна.

**Цэцэрлэгт хүрээлэн** (парк) - Байгалийн ой болон зориудаар мод үржүүлэх газарт ургуулсан мод, сөөгний суулгац бүхий нилээд их хэмжээний талбайг эзэлсэн ногоон байгууламж юм. Цэцэрлэгт хүрээлэн нь хотын төвд болон захад байж болно. Жишээ нь: Үндэсний соёл амралтын хүрээлэн.

**Цэцэрлэг** (сад) - Цэцэрлэгт хүрээлэнгээс бага талбайтай суурин газарт байгуулсан ногоон байгууламж юм. Цэцэрлэг нь ихэнх тохиолдолд байгаль орчны тогтоцын хэв төрх (Ландшафт)-ийн дагуу хааяа геометрийн дүрс хэлбэрээр (дугуй гурвалжин, дөрвөлжин г.м), зарим тохиолдолд дээрх хоёр хэлбэрийг хослуулсан байдаг. Жишээ нь: “Эмнэг сургагчтай цэцэрлэг”, Д.Нацагдоржийн хөшөөтэй цэцэрлэг, “Энхтайваны хонх”-той цэцэрлэг, Засгийн газрын ордны арын “Хувьсгалчдын цэцэрлэг” гэх мэт.

**Жижиг цэцэрлэг** (скверь) - Орон сууцны хороолол, галт тэрэгний буудал, замуудын уулзвар зэрэг 1 га хүртэлх хэмжээтэй газрыг цэцэрлэгжүүлсэн ногоон байгууламж юм. Жишээ нь: “Явуугийн цэцэрлэг”.

**Цэцэрлэгт гудамж** (бульвар) - Явган хүний хөдөлгөөнийг цэгцлэх зорилгоор өргөн гудамжны төв хэсэг, гол мөрөн, нуурын захаар 1-2 эгнээгээр мод цувруулан тарьж цэцэрлэгжүүлсэн газрыг хэлнэ. Хөдөлгөөнийг зохицуулсан цуваа цэцэрлэг нь өргөн гудамжийг дундуур нь хуваасан явган хүний замаас 3-5 м зайтай, заримдаа үүнээс илүү байх буюу замын 2 талд нарийхан зурвасаар зүлэгжүүлсэн байдалтай байна. Бульвар нь өргөн гудамжны 2 талд 10 м ба түүнээс дээш өргөнтэйгээр эгнээ мод тарьж гадна талаар нь бут, сөөгөөр хашлага хийсэн байдалтай. Бульварт модыг эгнээ хооронд 6м, мод хооронд 5-6 м зайтайгаар голдуу байгуулдаг. Захаар нь бут, сөөгийг 25-30 см зайтай суулган ургамлан хашлага хийнэ. Жишээ нь: Самбуугийн гудамж.

**Цуваа цэцэрлэг** (аллей) - Хот суурин газрын замыг салхи шуурга ус цасны нөлөөгөөр элэгдэж, эвдрэхээс хамгаалах, явган замыг машин замаас тусгаарлах, байшингийн нүүр, ханыг чимэглэж хөшиг болгон ашиглах зорилгоор замын 2 хажуугаар мод сөөг цувруулан суулгаж цэцэрлэгжүүлэхийг хэлнэ. Аллейд модыг нэг эгнээгээр хоорондоо 4-8 метр зайтай, ургамлан хашлаганд сөөгийг 25-30 см зайтай суулгана. Жишээ нь: Улаанбаатар хотод Бага тойруу, Сүхбаатар, Сүүл, МУИС-ийн гудамж, Энхтайван, Чингисийн өргөн чөлөөний явган замын дагуух цэцэрлэгжүүлэлт.

**4 дүгээр баганад:** Нийтийн эзэмшил газарт байгаа ногоон байгууламжийн хэмжээг нөхнө.

**5 дугаар баганад:** Авто болон явган хүний зам дагуух ногоон байгууламжийн хэмжээг нөхнө.

**6 дугаар баганад:** Аж ахуйн нэгж, байгууллагын орчмын ногоон байгууламжийн хэмжээг нөхнө.

**7 дугаар баганад:** Орон сууцны орчмын ногоон байгууламжийн хэмжээг нөхнө.

**8 дугаар баганад:** Гэр хорооллын өрхийн хашаанд байгуулсан ногоон байгууламжийн хэмжээг нөхнө.

6, 7, 8 дугаар багана нь хязгаарлагдмал хэрэгцээний ногоон байгууламжид хамаарагдана.

**Хязгаарлагдмал хэрэгцээний ногоон байгууламжид** сургууль, хүүхдийн цэцэрлэг, ясли, эмнэлэг, урлаг соёл, үйлчилгээний зэрэг аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн эзэмшиж, ашиглаж буй газарт (хашааны дотор, гадна гэх мэт) байгуулсан ногоон байгууламжийг хамруулна.

**9 дүгээр баганад:** Тусгай зориулалтын ногоон байгууламж бүхий газрын хэмжээг нөхнө.

**Тусгай зориулалтын ногоон байгууламж бүхий газарт** онцгой объектуудыг үер, гал түймрээс хамгаалах, усан сан, нуур цөөрмийг хамгаалах, түүний ууршилтыг багасгах, цэцэрлэгжүүлсэн талбайг хүн, малын хөл, зэрлэг амьтнаас хамгаалах, шарил оршуулах газрын урдуур хөшиг хэлбэрээр мод тарьж хаах зэргээр хот суурин орчмын доройтлыг багасгах, экологийн тэнцлийг хадгалах зорилгоор хамгаалалтын зориулалтаар байгуулсан ногоон байгууламж багтана.

**10 дугаар баганад:** Гол горхи, далан, суваг, бусад газарт барьж байгуулсан ногоон байгууламжийн хэмжээг нөхнө.

9, 10 багана нь тусгай зориулалтын ногоон байгууламж бүхий газарт хамаарна.